БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2026/027/НА-СТА-ТШЗ**

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баян-Өлгий аймаг<br>2026 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Нурлан<br>Утас: 99103281 Цахим хаяг:nurlans@ audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .......................................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.........................................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.................................................................................
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ................................................................................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......................................................................
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....................
4. Аудитын тайлан.........................................................................................................................
   4.1 Ерөнхий зүйл ..........................................................................................................................
   4.2 Материаллаг байдал ...............................................................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт................................................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...................................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............................................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..................................................................................
5. Аудитын илрүүлэлт ....................................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ...............................................................


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУЯНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Х.БАЯНБААТАР
ТАНАА

2026.02.13 № 68
танай ____________-ны № ____________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Буянт сумын Засаг даргын тамгын газар нь 883.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 850.1 сая төгрөг зарцуулж, 96.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

832605000317

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөг

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **14,229,395.00** | **14,229,395.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 14,229,395.00 | 14,229,395.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 14,229,395.00 | 14,229,395.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 774,000.00 | 774,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,164,716.00 | 1,164,716.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 290,679.00 | 290,679.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,000,000.00 | 12,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,238,851,092.01** | **3,264,549,393.44** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,238,851,092.01 | 3,264,549,393.44 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,232,771,713.34 | 3,258,470,014.77 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 508,732,189.00 | 549,642,189.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (235,865,134.71) | (262,573,198.07) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 212,149,995.00 | 192,149,995.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (136,749,662.54) | (133,679,995.08) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 78,227,153.00 | 88,227,153.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (39,358,397.12) | (49,130,400.76) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,752,752.00 | 36,752,752.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (26,045,246.68) | (26,045,246.68) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,325,445,040.21 | 4,476,844,693.21 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,497,516,974.82) | (1,620,717,926.85) |
| 39217 | Ном | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 6,079,378.67 | 6,079,378.67 |
| 39301 | Програм хангамж | 3,876,639.00 | 3,876,639.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,695,260.33) | (1,695,260.33) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,898,000.00 | 3,898,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,253,080,487.01** | **3,278,778,788.44** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **14,253,457.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 14,253,457.00 | - |
| **413** | **Өглөг** | 14,253,457.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 14,253,457.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 14,253,457.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,238,827,030.01** | **3,278,778,788.44** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,238,827,030.01 | 3,278,778,788.44 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 823,557,165.00 | 823,557,165.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 823,557,165.00 | 823,557,165.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,533,775,036.99 | 1,580,474,095.42 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,475,356,779.26 | 1,554,775,793.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 58,418,257.73 | 25,698,301.43 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 881,494,828.02 | 874,747,528.02 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,253,080,487.01** | **3,278,778,788.44** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөг

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **936,819,207.00** | **1,071,659,159.75** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **73,706,050.00** | **198,809,653.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 73,706,050.00 | 198,809,653.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 73,706,050.00 | 198,809,653.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **863,113,157.00** | **872,849,506.75** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 22,519,028.00 | 22,703,085.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 5,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,519,028.00 | 17,703,085.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 840,594,129.00 | 850,146,421.75 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 840,594,129.00 | 850,146,421.75 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **878,400,949.27** | **1,045,960,858.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **878,400,949.27** | **1,045,960,858.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 841,116,320.27 | 1,040,965,858.32 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 587,433,556.33 | 665,656,732.43 |
| 210101 | Үндсэн цалин | 327,955,339.66 | 364,886,866.96 |
| 210102 | Нэмэгдэл | 243,314,099.67 | 275,538,260.86 |
| 210104 | Урамшуулал | 16,164,117.00 | 25,231,604.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,441,700.00 | 83,251,946.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,660,300.00 | 56,635,446.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,195,300.00 | 6,654,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,097,700.00 | 3,327,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,097,700.00 | 3,327,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,390,700.00 | 13,308,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 59,644,400.00 | 60,210,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,750,661.00 | 2,620,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 57,893,739.00 | 57,590,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,711,078.00 | 21,446,339.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,428,300.00 | 3,724,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,719,278.00 | 11,070,489.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,146,500.00 | 4,363,950.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 2,127,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 297,000.00 | 160,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 611,500.00 | 438,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 611,500.00 | 438,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,036,000.00 | 1,768,289.32 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 926,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 50,000.00 | 57,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,060,000.00 | 1,710,789.32 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,224,000.00 | 1,093,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,224,000.00 | 1,093,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,656,143.67 | 5,850,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,641,000.00 | 4,989,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 10,000.00 | 99,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 108,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,926,023.67 | 654,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46,120.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 59,357,942.27 | 201,249,851.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,770,150.00 | 24,549,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 88,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,587,792.27 | 176,611,351.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 37,284,629.00 | 4,995,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,284,629.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 36,984,629.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 4,995,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,995,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **58,418,257.73** | **25,698,301.43** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **58,418,257.73** | **25,698,301.43** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөг

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **863,113,157.00** | **872,849,506.75** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **863,113,157.00** | **872,849,506.75** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 22,519,028.00 | 22,703,085.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 5,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,519,028.00 | 17,703,085.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 840,594,129.00 | 850,146,421.75 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 840,594,129.00 | 850,146,421.75 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **844,813,157.00** | **869,349,506.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **844,813,157.00** | **869,349,506.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **807,528,528.00** | **864,354,506.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 587,433,556.33 | 665,656,732.43 |
| 210101 | Үндсэн цалин | 328755339.66 | 364036016.96 |
| 210102 | Нэмэгдэл | 242514099.67 | 276389110.86 |
| 210104 | Урамшуулал | 16164117.00 | 25231604.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,441,700.00 | 83,251,946.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52660300.00 | 56635446.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6195300.00 | 6654200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3097700.00 | 3327000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3097700.00 | 3327000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12390700.00 | 13308300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 60,175,800.00 | 60,509,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1560000.00 | 2040000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 58615800.00 | 58469000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,850,523.95 | 17,337,039.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,860,745.95 | 1,741,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,219,278.00 | 11,217,139.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,353,500.00 | 3,736,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 349,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 297,000.00 | 292,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 611,500.00 | 649,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 611,500.00 | 649,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,300,877.72 | 2,089,389.32 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,171,077.72 | 362,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 69,800.00 | 15,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,060,000.00 | 1,710,789.32 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,224,000.00 | 1,093,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,224,000.00 | 1,093,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,189,820.00 | 7,421,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,154,300.00 | 6,509,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 6,700.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 10,000.00 | 46,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 98,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 30,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 928,600.00 | 712,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46,120.00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 11,100.00 | 25,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,300,750.00 | 26,346,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,238,750.00 | 26,029,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,062,000.00 | 316,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **37,284,629.00** | **4,995,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,284,629.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 36,984,629.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 4,995,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 4,995,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **18,300,000.00** | **3,500,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **18,300,000.00** | **3,500,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **18,300,000.00** | **3,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 18,300,000.00 | 3,500,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 18,300,000.00 | 3,500,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(18,300,000.00)** | **(3,500,000.00)** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөг

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 823,557,165.00 | 881,494,828.02 | 1,475,356,779.26 | 3,180,408,772.28 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **823,557,165.00** | **881,494,828.02** | **1,475,356,779.26** | 3,180,408,772.28 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 58,418,257.73 | 58,418,257.73 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **823,557,165.00** | **881,494,828.02** | **1,533,775,036.99** | 3,238,827,030.01 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **823,557,165.00** | **881,494,828.02** | **1,533,775,036.99** | 3,238,827,030.01 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | -6,747,300.00 | 21,000,757.00 | 14,253,457.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **823,557,165.00** | **874,747,528.02** | **1,554,775,793.99** | 3,253,080,487.01 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 25,698,301.43 | 25,698,301.43 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **823,557,165.00** | **874,747,528.02** | **1,580,474,095.42** | 3,278,778,788.44 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөг

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 883,571,100.00 | 850,146,421.75 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 883,571,100.00 | 850,146,421.75 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 883,571,100.00 | 850,146,421.75 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 660,998,400.00 | 665,005,032.43 |
| 210101 | Үндсэн цалин | 356,665,700.00 | 364,036,016.96 |
| 210102 | Нэмэгдэл | 279,752,700.00 | 276,389,110.86 |
| 210104 | Урамшуулал | 24,580,000.00 | 24,579,904.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 83,177,000.00 | 83,177,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,560,500.00 | 56,560,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,654,200.00 | 6,654,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,327,000.00 | 3,327,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,327,000.00 | 3,327,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,308,300.00 | 13,308,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 59,630,800.00 | 59,629,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,950,000.00 | 1,950,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 57,680,800.00 | 57,679,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,342,100.00 | 15,765,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,264,100.00 | 1,741,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,258,000.00 | 9,885,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,535,000.00 | 3,496,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 700,000.00 | 349,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 585,000.00 | 292,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 778,500.00 | 649,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 778,500.00 | 649,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,811,700.00 | 2,089,389.32 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 621,700.00 | 362,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 190,000.00 | 15,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 1,710,789.32 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,070,700.00 | 1,093,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,070,700.00 | 1,093,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 41,230,900.00 | 7,421,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,947,200.00 | 6,509,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 503,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 184,800.00 | 46,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 392,000.00 | 98,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 120,400.00 | 30,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 905,000.00 | 712,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 128,500.00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 50,000.00 | 25,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,531,000.00 | 15,316,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,000,000.00 | 14,999,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 531,000.00 | 316,900.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 883,571,150.00 | 850,146,421.75 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 883,571,150.00 | 850,146,421.75 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 883,571,150.00 | 850,146,421.75 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **22.00** | **19.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9.00 | 7.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 7.00 | 6.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6.00 | 6.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөг

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **22,519,028.00** | **17,708,085.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **22,519,028.00** | **17,708,085.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 22,519,028.00 | 17,708,085.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | 651,700.00 |
| 210104 | Урамшуулал | | 651,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | 74,946.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 74,946.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,370,000.00 | 880,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 60,000.00 | 90,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,310,000.00 | 790,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 930,278.00 | 1,571,439.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 930,278.00 | 1,331,439.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 240,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 680,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 680,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,538,750.00 | 14,530,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,538,750.00 | 14,530,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **4,995,000.00** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 4,995,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 22,519,028.00 | 22,703,085.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 22,519,028.00 | 22,703,085.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,519,028.00 | 22,703,085.00 |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 1-01/19 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 878.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор

мэдээлэх"-ээс 64.4 сая төгрөгийн 11 гүйлгээг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 81.9 сая төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16.7 сая төгрөгийн 11 гүйлгээг бүгд 163.1 сая төгрөгийн 25 гүйлгээг ил тод мэдээлээгүй ба шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 76.5 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд байршуулаагүй бүгд 163,146.5 мянган төгрөгийн 25 гүйлгээг нөхөж байршуулах зөрчил арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 3,698.5 | 1 | 3,698.5 | 100% |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1 | 22,000.0 | 1 | 22,000.0 | 100% |
| **Нийт дүн** | **2** | **25,698.5** | **2** | **25,698.5** | 100% |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өмч хөрөнгийн бүртгэл тооллого, шилэн дансны мэдээлсэн байдлыг анхаарах шаардлагатай байна.

# 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 47.9 сая төгрөгийн алдаа  илэрч аудитын явцад залруууллаа. Үүнд:

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлэн шилжүүлсэн 4.9 сая төгрөгийг "Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг"-ээр тайлагнаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 165.6 сая төгрөгийн зөрчил илэрч 0.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 165.5 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар 107.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

1.Сумын Засаг даргын тамгын газар нь цалингаас нийтдээ 55,951.5 мянган төгрөгийн татвар ногдуулан суутгаж 55,844.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлснээс 107.0 мянган төгрөгийг төсөвт дутуу шилжүүлж санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” , 14.4.3 “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.6-д “бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт дутуу төвлөрүүлсэн 107.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар 165.5 сая төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

1.Төсвийн хөрөнгийг зарцуулах эрх бүхийн албан тушаалтны холбоотой тушаал шийдвэр гаргуулаагүй мөн түлш, халаалтын зардлаас амьжиргааны түвшин доогуур гэх үндэслэлээр 2 иргэнд 2.3 сая төгрөгийн нүүрс олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй, батлагдсан төсвийн зориулалтын бус зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Шилэн дансанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор мэдээлэх"-ээс 64.4 сая төгрөгийн 11 гүйлгээг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 81.9 сая төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16.7 сая төгрөгийн 11 гүйлгээг бүгд 163.1 сая төгрөгийн 25 гүйлгээг ил тод мэдээлээгүй ба шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 76.5 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд байршуулаагүй бүгд 163,146.5 мянган төгрөгийн 25 гүйлгээг нөхөж байршуулах зөрчил арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### 5.3 Зөвлөмж

### 1.Түлш халаалтын зардлын төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Буянт сумын ЗДТГ-ын дарга 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр “Акбейл” ХХК-тай дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулахдаа Эрчим хүчний зохицуулах хорооны хүчингүй болсон 2014 оны 189 дүгээр тогтоолыг үндэслэл болгосон, гэрээнд байгууллагын халаалт авах нийт талбайн хэмжээ, сар бүр төлөх төлбөрийн мөнгөн дүнг тодорхой тусгаж өгөөгүй байна. Тайланд оны халаалтын зардлын төсвөөс 54,808.8 мянган төгрөгийг дулаанаар хангагч “Акбейл” ХХК-нд бүрэн шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 зүйлийн 15.2.1-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж**:**

Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг Эрчим хүчний тухай хууль болон Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 164 дүгээр тогтоолоор баталсан “Дүрэм шинэчлэн батлах тухай” дүрэмд нийцүүлэн шинэчлэн байгуулах, гэрээнд халаалт авах талбайн хэмжээ, төлбөрийн мөнгөн дүнг тодорхой тусгаж, халаалтын зардлын төсвийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулах;

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлэн шилжүүлсэн 4,995.0 мянган төгрөгийг тусгаагүй байна. | 1 | 4,995.0 | 1 | 4,995.0 | | | 1 | 4,995.0 | | | | |
| **Дүн** | **1** | **4,995.0** | **1** | **4,995.0** | | | **1** | **4,995.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ХХОАТ-ын 107.0 мянган төгрөгийг төсөвт дутуу шилжүүлж | 1 | 107.0 | 1 | 107.0 | | | | | | | | |
| Төсвөөс 2,380.0 мянган төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан | 1 | 2,380.0 | | | 1 | 2,380.0 | | | | | | |
| Халаалтын гэрээнд халаалтын талбай, төлөх мөнгөн дүнг тодорхой тусгах, хяналтыг сайжруулах | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **3** | 2,487.0 | 1 | 107.0 | 1 | 2,380.0 | **1** | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны хэрэгжилт хангалтгүй хэрэгжилт 76.5 хувьтай. | 1 | 163,146.5 | | | 1 | 163,146.5 | | |
| **Дүн** | **1** | **163,146.5** | | | **1** | **163,146.5** | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |